

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ,
УГ АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД ТӨРИЙН АЛБАТАЙ
ХОЛБОГДСОН АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүнээс 2017 оны хоёрдугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дугаар зүйлд “Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор “.....холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэн батлах, хүчингүй болгох”-ыг Засгийн газарт даалгасан байна.

Энэхүү журмын төслийг боловсруулахдаа дор дурдсан хууль тогтоомжид нийцүүлэв. Үүнд.

- Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга),
- Захиргааны ерөнхий хууль,
- Хууль тогтоомжийн тухай хууль,
- Улсын Их Хурлаар батлагдсанаар Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”,

Төрийн албаны төв байгууллагын маргаан хянан шалгах ажиллагаа нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө хийгддэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа юм. Уг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд Төрийн албаны зөвлөл болон түүний Салбар зөвлөл хэрэгжүүлдгээр онцлог бөгөөд заавал хийгдэх шинжийг агуулдаг.

Журмын төслийг боловсруулах явцад Төрийн албаны зөвлөлд 2014-2017 оны хооронд төрийн албан хаагч болон иргэдээс ирүүлсэн **2282** өргөдөл, гомдолтой танилцаж дүн шинжилгээ хийлээ.

Мөн өргөдөл, гомдол гаргасан зарим иргэд болон төрийн албан хаагч нартай уулзалт ярилцлага хийж маргаан гарч буй шалтгаан, хянан шийдвэрлэхэд анхаарах зүйлс зэргийг судлан үзлээ.

Журмын төслийг боловсруулахдаа одоо хэрэгжүүлж байгаа журмын үйлчлэл, практикт гарч буй зөрчил, маргаан болон БНСУ, Канад, БНХАУ болон Казахстан

улсуудын төрийн албаны удирдлага, гомдол, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад бий болсон ололт, амжилт, туршлагад мөн тулгуурласан болно.

“Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын төсөл нь 5 бүлэг 15 зүйлтэй бөгөөд дараах асуудлуудыг тусгалаа. Үүнд:

- Нэгдүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл болон журмын зорилго, үйлчлэх хүрээ, хууль зүйн эх сурвалж, нэр томъёоны тодорхойлолт, маргаан хянан шийдвэрлэх зарчим,
- Хоёрдугаар бүлэгт Төрийн албаны зөвлөлийн шийдвэрлэх маргаан,
- Гуравдугаар бүлэгт гомдолд тавигдах шаардлага, гомдол гаргах эрх бүхий этгээдийг,
- Дөрөвдүгээр бүлэгт гомдлыг хүлээн авах, маргаан хянан шалгах комисс байгуулах,
- Тавдугаар бүлэгт Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар маргааныг хянан шийдвэрлэх болон шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх зэргийг тус тус тусган орууллаа.

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах буюу чадахуйн /мерит/ зарчмыг, мөн төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх, төрийн байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэл үр дүн, хариуцлага гэх зэрэг шинэлэг зохицуулалтууд тусгагдсан.

Иймд Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд энэ хуулийн 25, 26, 27, 45, 46, 47, 48 дугаар зүйл, 52.2, 66.1.11-д заасан асуудлаар гарсан маргаан болон төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг Төрийн албаны зөвлөл хянан шийдвэрлэх, хууль бус захиргааны актыг хүчингүй болгох, төрийн албан хаагчийн болон иргэний зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн орчинг улам боловсронгуй болгож энэхүү журмын төслийг хэлэлцэн батлах нь хууль эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой юм.

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ,
УГ АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД ТӨРИЙН АЛБАТАЙ
ХОЛБОГДСОН АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ”-ын төслийн үзэл баримтлал**

Нэг. Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэгийг боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлага:

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан.

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан “Төрийн албаны тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 75 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолын 5 дугаар зүйлд “Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор “.....холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэн батлах, хүчингүй болгох”-ыг Засгийн газарт даалгасан.

Мөн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” МОН/18/101 төслийн хүрээнд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэгийг боловсруулах ажил багтсан байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 75 дугаар зүйлийн 75.1-д “...энэ хуулийн 25, 26, 27, 45, 46, 47, 48 дугаар зүйл, 52.2, 66.1.11-д заасан асуудлаар гарсан маргаан болон төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ” гэж мөн зүйлийн 75.6-д “Энэ хуулийн 75.1-д заасан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг **Улсын Их Хурал тогтооно.**” гэж тус тус заасан.

Мөн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 75, 76 дугаар зүйлд Төрийн албаны төв байгууллагын маргаан хянан шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэх үйл ажиллагаан, маргаан хянан шалгах комиссын эрх үүрэг болон шийдвэр, хариуцлагын талаар шинээр зохицуулалтууд тусгагдсан.

Иймд одоо үйлчилж буй Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам” “Төрийн албаны тухай хууль (шинэчлэн найруулсан)-ийн үзэл баримтлал, агуулга, зарчимд нийцэхгүй болсон тул уг журмыг шинэчлэн боловсруулах хууль, эрх зүйн шаардлага гарч ирж байгаа юм.

Хоёр. “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан

маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын төслийн зорилт, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Энэхүү журмын төсөл нь 5 бүлэг 15 зүйл бөгөөд уг журам нь “Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөл Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 75 дугаар зүйлийн 75.1-д заасан асуудлаар гарсан маргааныг хүлээн авах, хянан шийдвэрлэх, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Засгийн газрын хэрэг Эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлөөс хамтран 2018 оны 09 дүгээр сарын 20-21-ний өдөрүүдэд зохион байгуулсан “Төрийн албаны удирдах албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн”-ийн хоёр дахь өдөр болсон салбар хуралдаанд уг журмын төслийг танилцуулж, оролцогчдоос санал авсан бөгөөд салбар хуралдаанд 450 гаруй төрийн албан хаагчид оролцсон болно.

Гурав. Энэхүү журмын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

Энэхүү журмын төслийг Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль тогтоомжийн тухай хууль бусад хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд уг журам батлагдсанаар Улсын Их Хурлаар батлагдсанаар Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ыг хүчингүйд тооцох юм.

Энэхүү журмын төслийг хэлэлцэн батлагдсанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон уг хууль заасан Төрийн албаны төв байгууллагын эрх бүрэн хангагдах боломжтой юм.

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ, УГ АЛБАН
ТУШААЛД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДСОН
АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ
/шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилт нь Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөл Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд Төрийн албан тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан т асуудлаар гарсан маргааныг хүлээн авах, хянан шийдвэрлэх, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэхэд баримтлах хууль тогтоомж

2.1. Энэ журмын 1.1.-д заасан маргааныг хянан шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг баримтална

2.2. Энэ журмын 1.1-д зааснаас бусад асуудлаар гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. **“гомдол”** гэж энэ журмын 5, 6 дугаар зүйлд заасан асуудлаар өөрийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг;

3.1.2. **“маргаан”** гэж Төрийн албаны тухай хууль болон энэ журамд заасны дагуу төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан нэр дэвшигчийн хооронд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, шийдвэр, үйл ажиллагаа болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгаатай холбогдон гарсан асуудлаар үүсэн саналын зөрүүг;

3.1.3. “**маргалдагч тал**” гэж энэ журмын 8 дугаар зүйлд заасан этгээд болон захиргааны акт гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанг;

3.1.4. “**төрийн албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр**” гэж төрийн жинхэнэ албанд нэр дэвшигч болон төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулж нэр дэвшүүлэх, шатлан дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, дэвшүүлэх, үр дүнгийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, зэрэг дэв олгох, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг хүний нөөцөд холбогдох асуудлаар гаргасан захиргааны актууд хамаарна

4 дүгээр зүйл. Маргаан хянан шийдвэрлэх зарчим

4.1.Төрийн албатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд дараах зарчмыг баримтална

4.1.1.ил тод, шударга байх;

4.1.2.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

4.1.3.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, тасралтгүй байх:

4.1.4.маргалдагч талын эрх, хууль ёсны ашиг сонирхлын хөндсөн маргааныг шийдвэрлэх тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах;

4.1.5.хуульд үндэслэх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МАРГААН

5 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөл нь дараах маргааныг хянан шийдвэрлэнэ

5.1. Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд томилохтой холбогдож гарсан маргаан;

5.2.Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгууртай холбогдож гарсан маргаан;

5.3.Төрийн албаны тухай хуулин 27 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой хологдож гарсан маргаан;

5.4.Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулж тушаалаас бууруулсантай холбогдож гарсан маргаан;

5.5.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх, чөлөөлсөнтэй холбогдож гарсан маргаан;

5.6.Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь халсантай холбогдож гарсан маргаан;

5.7.Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсантай холбогдож гарсан маргаан;

5.8.Төрийн албан тухай хуулийн 52.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудалтай холбогдож гарсан маргаан;

5.9.Төрийн албаны тухай хуулийн 66.1.11-т заасан төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулахтай холбогдож гарсан маргаан;

5.10.төрийн албан хаагчаас Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн маргаан;

5.11.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын өөрийнх нь гомдлоор үүссэн маргаан.

5.12.Төрийн албаны тухай хуулийн 75.1-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан;

6 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хянан шалгах маргаан

6.1.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах маргааныг хянан шалгана.

6.1.1.Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд томилохтой холбогдож гарсан маргаан;

6.1.2.Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгууртай холбогдож гарсан маргаан;

6.1.3.Төрийн албаны тухай хуулин 27 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой хологдож гарсан маргаан;

6.1.4.Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулж тушаалаас бууруулсантай холбогдож гарсан маргаан;

6.1.5.Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.1.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсантай холбогдож гарсан маргаан;

6.1.6.Төрийн албан тухай хуулийн 52.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудалтай холбогдож гарсан маргаан;

6.1.7.Төрийн албаны тухай хуулийн 66.1.11-т заасан төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг зохион байгуулах,

арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулахтай холбогдож гарсан маргаан;

6.1.8.Төрийн албаны тухай хуулийн 75.1-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан;

6.2.Салбар зөвлөл нь энэ журмын 6.1-д заасан маргааныг хянан шалгаад төрийн албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгуулах тухай саналаа нотлох баримтын хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГОМДОЛ ГАРГАХ, МАРГААН ҮҮСГЭХ,

7 дугаар зүйл.Гомдол гаргах

7.1.Энэ журмын 9 дүгээр зүйлд заасан этгээдээс төрийн албатай холбогдсон асуудлаар гаргах гомдлоо мөн журмын 5,6 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу бичгээр ирүүлнэ.

7.2.Гомдолд маргаан үүсэх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой дурдаж холбогдох нотолгоо, баримт бичгийн хуулбарыг хавсаргаж ирүүлэхээс гадна дараах шаардлагыг хангасан ирүүлэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна.

7.2.1. Гомдолд овог нэр, эрхэлж буй албан тушаал, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж өөрийн гарын үсэг зурна,

7.2.2.Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно,

7.2.3.Маргаанд холбогдох асуудлаар 2 ба түүнээс дээш этгээд гомдлыг бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үүсэг зурна. Энэ тохиолдолд гомдолд төлөөлөх эрхийн нотлох баримт бичгийг хавсаргана.

7.3.Энэ журмын 8 дугаар зүйлд заасан этгээд маргаан бүхий захиргааны акт болон шийдвэрийг хуульд заасны дагуу хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг холбогдох баримт бичгийн хамт Төрийн албаны зөвлөл болон түүний Салбар зөвлөлд гаргана.

8 дугаар зүйл. Төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг дор дурдсан этгээдийн гомдлоор үүсгэнэ

8.1.Энэ журамд заасан маргааны дараах этгээдийн гомдлоор үүсгэнэ.

8.1.1.төрийн албан хаагчаас гаргасан гомдлоор;

8.1.2.Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад оролцсон иргэнээс гаргасан гомдлоор

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, МАРГААН ХЯНАН ШАЛГАХ КОМИСС БАЙГУУЛАХ

9 дүгээр зүйл. Гомдлыг хянан шалгах

9.1. Төрийн албаны зөвлөл гомдлыг хүлээн аваад дараах ажиллагааг явуулна:

9.1.1.энэ журмд заасан харьяаллын бус бол маргаан үүсгэхээс татгалзаж гомдлыг харьяалах байгууллагад 3 хоногийн дотор шилжүүлж, энэ тухай гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

9.1.2.гомдлыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргана.

10 дугаар зүйл.Маргааныг хянан шалгах комисс байгуулах

10.1.Гомдолд дурдсан маргааны шинж байдлыг харгалзан маргаан хянан шалгах комисс /цаашид "комисс" гэх/-ыг 3-5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр Төрийн албаны зөвлөлийн дарын шийдвэрээр байгуулна.

10.2.комиссыг Төрийн албаны зөвлөлд зөвлөлийн аль нэг гишүүн даргална.

10.3.комиссын бүрэлдэхүүнд Төрийн албаны зөвлөлийн гишүүн, ажлын албаны ажилтан, тухайн салбар зөвлөлийн гишүүн, түүнчлэн төрийн захиргааны бусад байгууллагаас төрийн албаны ажлын туршлагатай, мэргэшсэн албан хаагчийг оролцуулж болно.

10.4.гомдлыг хянан шалгах ажлыг комиссын дарга хариуцан зохион байгуулна.

10.5.комиссын гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх үүрэгтэй.

10.6.комисс нь маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 14 хоногоор сунгаж болно.

11 дүгээр зүйл. Комиссын эрх, үүрэг

11.1.Комисс нь маргааныг хянан шалгахдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.маргалдагч талуудаас болон бусад холбогдох этгээдээс тайлбар авах;

11.1.2.Холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;

11.1.3.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

11.1.4.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

11.1.5.илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

11.1.6.хяналт шалгалт, дүгнэлт, танилцуулга, албан шаардлага, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

11.1.7.маргааныг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацааны дотор, ил тод, хуулийн дагуу шалган шийдвэрлэх;

11.1.8.комисс маргааныг хянан шалгасан дүнг хуралдаанаараа хэлэлцэж, комиссын гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргах;

11.1.9.зөвлөлийн хуралдаанд маргаан хянан шийдвэрлэсэн комиссын танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг танилцуулах;

1.1.10.Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Комиссын үйл ажиллагааны зохион байгуулалт

12.1.Комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Хуралдааныг комиссын дарга удирдан явуулна.

12.2.Комиссын нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцүүлэх баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг бүрдүүлэх, бэлтгэх, олшруулах, тараах зохион байгуулж, хяналт тавина хуралдааны бэлтгэл ажлыг хангаж хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө.

12.3.Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд комиссын хуралдаанаас гарсан дүгнэлтийг комиссын дарга, нарийн бичгийн дарга танилцуулна.

12.4.Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан хуралдаанд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны болон бусад байгууллагын удирдлага, холбогдох бусад хүмүүсийг оролцуулж болно. Оролцогч хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгөөр үг хэлж болно.

12.5.Хуралдаанаар шийдвэрлэсэн асуудалд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах бол заавал хуралдаанаар дахин хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Комиссын дүгнэлт, дүгнэлтийн агуулга

13.1.Дүгнэлт нь аливаа албан тушаалтан, улс төрийн хүчний нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байна.

13.2.Дүгнэлт нь удиртгал, үндэслэх, дүгнэх гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд дараах агуулга бүхий байна.

13.2.1.удиртгал хэсэгт дүгнэлтийн дугаар, гаргасан он, сар, өдөр, комиссын дарга болон бусад гишүүд, нарийн бичгийн дарга, гомдол гаргагчийн овог нэр, эрхэлж буй албан тушаал, дүгнэлт гарах болсон үндэслэлийг заана.

13.2.2.үндэслэх хэсэгт маргаан хянан шалгах явцад цугларсан нотлох баримтад дүн шинжилгээ хийж, холбогдох үйл баримтыг тодорхойлно. Ямар нотлох баримтыг хүлээн зөвшөөрсөн, ямар нотлох баримтаас татгалзсан зэргийг дэлгэрэнгүй тайлбарлаж дүгнэлт гаргаж буй хууль, эрх зүйн үндэслэлийг тодорхой заасан байна.

13.2.3.дүгнэх хэсэг нь дүгнэсэн хэлбэртэй байх бөгөөд үндэслэх хэсэгт дурдагдсан үндэслэлд тулгуурласан байна. Асуудлыг хэрхэн шийдвэрлэж дүгнэлт гаргаж буй нь ямар нэг эргэлзээ төрөхгүйгээр, хоёрдмол утгагүй тодорхой заана:

14 дүгээр зүйл. Хориглох зүйл.

14.1.Комиссын бүрэлдэхүүнд гомдол гаргасан этгээдтэй эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн болон бусад нэгдмэл сонирхолтой хамаарал бүхий ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг оруулахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ.МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

15 дугаар зүйл. Маргааныг хэлэлцэн шийдвэрлэх.

15.1.Төрийн албаны зөвлөл зөвлөлийн хуралдаанаар комиссын дүгнэлтийг хянан хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

15.2.Төрийн албаны зөвлөл зөвлөлийн хуралдаанаар дүгнэлтийг хэлэлцээд, тогтоол гаргана.

15.3.Төрийн албаны зөвлөл төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол өөрчлөх буюу хүчингүй болгоно.

15.4.Төрийн албаны зөвлөл дараах тохиолдолд маргааныг дахин шалгуулахаар комисст буцаах шийдвэр гаргана.

15.4.1.шийдвэр гаргахад нотолгоо болох баримт бичгийн бүрдэл хангагдаагүй;

15.4.2.маргаанд холбогдох баримт бичиг, бусад материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан;

15.4.3.маргалдагч талуудын оролцоог бүрэн хангаагүй;

15.4.4.комисс маргааныг хянан шалгасан дүнг хуралдаанаараа хэлэлцээгүй;

15.4.5.маргаанд холбогдох асуудлаар хууль, шүүхийн байгууллагад хандсан байгаа болон тухайн асуудлаар хэрэг үүсгэн шалгагдаж байгаа.

15.5. Төрийн албаны зөвлөл гаргасан шийдвэрээ ажлын 3 өдөрт багтаан албажуулж, маргагч талуудад мэдэгдэж, түүнийг баримтжуулна.

15.6. Төрийн албаны зөвлөл зөвлөлийн гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

15.7. Төрийн албаны зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтан шийдвэрийн албан ёсоор хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн хугацаанд хариу ирүүлнэ.

15.8. Энэхүү журмын 16.6-д заасныг зөрчсөн этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага тооцох үндэслэл болно.

15.9.Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргаж болно.

-----oO-----